



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ 02 ДУГААР САРЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2026 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2026 ОНЫ 02 ДУГААР САРЫН ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 06

Улаанбаатар хот

НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1.“Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.” зорилтын хүрээнд:

1.1.1.Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, хот орчмын байгалийн үзэсгэлэн, соёл, ахуйг сурталчлан таниулах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль” арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдөр, Казах үндэстэн ястны ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор “Бүргэдийн баяр” арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажилласан.



1.2.“Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилах” чиглэлээр:

1.2.1.“Улаанбаатарын өвлийн наадам”, “Талын жавхаа”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, зэрэг 4 арга хэмжээний танилцуулга 6 видео, контент хийж байгууллагын www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net цахим хуудас болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд байршуулж 4,992,728 хүнд хүргэсэн байна.



Posts

About

Photos

Reels

More ▼

A total of 45 participants from both domestic and international backgrounds will participate in the event. This includes 22 eagle hunters from the Bayan-Ulgii, Tuv, and Selenge provinces of Mongolia, as well as 15 eagle hunters from the the Republic of Kazakhstan, the Kyrgyz Republic, the Kingdom of Spain, Hungary, and the Russian Federation.

March 7–8, 2026

11:00 AM – 6:00 PM

Chinggis Khaanii Khuree Tourism Complex

Online ticket sales: <https://ticket.mn/event/2916>

Offline ticket sales:

◆ Ticket.mn Office (5th floor, Khan Bank Building, Sports Palace area),

◆ M Trip, B1 floor, Shangri-La Mall

◆ E-Mart branches (Customer Service Centers) and on-site at the Chinggis Khaanii Khuree Tourism Complex during event days)

Ticket price: MNT 15,000

Contact numbers: +976 7510-1727, 8851-1727, 9910-1727, 9595-1727



Нийслэлийн Аялал жуулчлалын газар / Ulaa...
4d · 🌐

“УЛААНБААТАР ӨВЛИЙН ЯВГАН АЛХАЛТ 2026” ОЛОН УЛСЫН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДАН... more




ХОЁР.ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1.Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;

2.1.1. “Онлайн бизнес төв” нэгдсэн мэдээллийн системийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэл” цэсэд 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр нийт 81 хүсэлт ирснээс зөвшөөрсөн 37, хариуцсан дүүрэгт шилжүүлсэн 13, буцаагдсан 30 төлөвтэй байна.

2.2. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

2.2.1. Шашин, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Гандантэгчинлэн хийдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан “Цам харайх” ёслол, “Майдар эргэх” ёслол, “Лянх мордох” ёслолыг тогтмол эвент арга хэмжээ болгон зохион байгуулах талаар санал солилцлоо. Мөн Монголын үндэсний төв номын санд 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан “Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа” санал солилцох уулзалтад Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх болон холбогдох албан хаагчид оролцлоо.



2.3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

2.3.1. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн татварын газартай хамтран “Аялал жуулчлалын салбар дахь татвар, даатгал, байгууллагын менежмент, үнэ бодолт” сэдэвт сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулан аялал жуулчлалын салбар дахь татварын орчин, татварын тухай шинэчилсэн хууль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, нийгмийн даатгалын тухай багц хуулиудын тухай ойлголт, зохицуулалт, ажил олгогч, даатгуулагчийн эрх, үүрэг түгээмэл гардаг алдаа, анхаарах асуудлууд, салбарын болон зочлох үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй

стандартуудын талаар мэдээлэл хүргэж, сургалтад бизнес эрхлэгч, аж аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл нийт 72 хүн хамрагдлаа.

**“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ДАХЬ
ТАТВАР-ДААТГАЛ-
ХАРИЛЦААНЫ МЕНЕЖМЕНТ- ДИПЛОМАТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТ”**

2026 оны 02 сарын 10-ны өдөр
ХАМРАХ ХҮРЭЭ: Жуулчны бааз болон
Тур операторын бизнес эрхлэгч нарт



ХУД 23-Р ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2 ДАВХАРТ, 207 ТООТ 77128822, 99959605

**Байгууллагын Орлогын
МЕНЕЖМЕНТ, ҮНЭ БОДОЛТ**


2026 ОНЫ 02 САРЫН 11-НИЙ ӨДӨР 10:00 ЦАГТ
ЖББХСХ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГАА ЭЗЛЖИТ
СУРГАЛТАНДАА ТА БҮХНИЙГ УРЬЖ БАЙНА



ЯРМАГ ХАНГАРЬД ОРДОН Б
БАЙРНЫ 2 ДАВХАРТ 204 ТООТ 99198811, 99093339





2.3.2. Болзошгүй гамшиг, ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль эрх зүй, стандарт, аюулгүй байдлын чиглэлээр мэдлэг олгох зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо, ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах сургалтын төвийн 116 дугаар ангитай хамтран “Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, зарлан мэдээлэл, нүүлгэн шилжүүлэлт, гамшиг ослын үед анхан шатны тусламжийг хэрхэн шуурхай, үр дүнтэй хүргэх зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч сургалтад байршуулах үйлчилгээний байгууллагуудын нийт 70 гаруй ажилтан, албан хаагч хамрагдлаа.



2.4. “Жуулчны мэдээллийн төв”-үүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

2.4.1. Нийслэлийн Засаг даргын 2026 оны “Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/107 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, Сөүлийн гудамж дахь “Урухан” брэндийн гэр мэдээллийн төв болон ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв зэрэг 4 байршилд ажиллуулж 2025 оны 02 дугаар сард гадаад, дотоодын 811 хүнд үйлчилгээ үзүүлж, Улаанбаатар хотын сурталчилгааны 432 ширхэг материалыг түгээж ажиллаа.

Улс орноор жуулчдын тоо (өнгөөр ялгасан)



ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

3.1.Захиргааны үйл ажиллагаа, төлөвлөлт, тайлагналтын чиглэлээр:

3.1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2026 оны “Хариуцлагын гэрээ”-г 6 бүлэг 48 заалтаар, Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын хүрээнд 12 зорилтын 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулав.

3.1.2. Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хариутай 25 албан бичиг, хариугүй 48 албан бичиг нийт 73 албан бичгийг бүртгэж, 96 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан бусад байгууллагуудад илгээсэн. Ирүүлсэн 70 албан бичгийг бүрэн шийдвэрлэж 3 албан бичиг судлагдаж байна. Ирсэн албан бичгийг 100 хувь шийдвэрлэж ажиллаа.

3.1.3. Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 3 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Нийт өргөдөл, гомдлоос албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол болон саналын шинжтэй өргөдөл ирээгүй бөгөөд шийдвэрлэлтийн явцад хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 09 цаг 44 минут байна.

3.1.4. Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn, www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд давхардсан тоогоор нийт 359 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 1,510,351 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан.

Тухайлбал:


www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 43 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 2500,

www.visit-ulaanbaatar.com цахим хуудсанд 10 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 200,483

<https://www.facebook.com/UlaanbaatarTourism> цахим хуудсанд 287 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 37,744 хандалтын тоо 1,088,647

<https://www.instagram.com/visit.ulaanbaatar/> цахим хуудсанд 13 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 413, хандалтын тоо 210,394

<https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA> цахим хуудсанд 6 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 530, хандалтын тоо 8,327 байна.



3.1.5. Сар шинийн баярыг угтаж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас санаачлан 2026 оны 02 сарын 10-15 ны өдрүүдэд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд оролцох уриалгыг Монголын Аялал жуулчлалын холбоо, Аялал

жуулчлалын мэргэжлийн холбоо, “Өргөө” дэн буудал эрхлэгчдийн холбоо, Монголын зочид буудлын нэгдсэн холбоо, Монголын рестораны нэгдсэн холбоодуудад албан бичгээр хүргүүлж, мөн Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 16 албан хаагч батлагдсан хуваарийн дагуу С.Жамъяан Гүнгийн гудамжны гаднах орчны цэвэрлэгээг 2026 оны 02 сарын 13-ны өдрийн 09:30-11:30 цагийн хооронд зохион байгуулав.



ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ, БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ